



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/11/СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2020 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: В.Цэнгэлмаа

Утас: 70584204 Цахим хаяг: tsengelmaav@audit.gov.mn

Аудитор: Ж.Баяртуул

Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.11. Шилэн дансны мэдээлэл	11
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	11
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
3.1 Төлөвлөлттэй холбоотой холбоотой асуудал	12
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	14
4.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	20
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ИТХ	Иргэдийн төлөөлөгчийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
СХС	Сум хөгжлийн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ДОА	Дорнод аймаг
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. Аудитын гэрчилгээ

		МАТАД СУМЫН ЗАСАГ ДАРГА Э.ТӨМӨРБААТАР ТАНАА	
ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР			
21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг Э/ДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203			
Огноо 03.25 № 310			
танай	-ны №	-Т	
Аудитын гэрчилгээ			
Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Матад сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.			
Зөрчилгүй санал дүгнэлт			
Матад сумын төсвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.			
Санал дүгнэлтийн үндэслэл			
Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.			
Аудитаар Матад сумын төсвийн гүйцэтгэлийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.			
Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.			
110520256			



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Э.Төмөрбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн төлөвлөлттэй холбоотой зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Матад сумын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 15-аас 2020 оны 03 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Баяртуул хариуцаж гүйцэтгэв.

Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 1/93 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Матад сумын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, журамд өөрчлөлт гараагүй байна.

Матад сумын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2019 онд Матад сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

2.5. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Матад сумын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 15 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.6. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг нийт зардлын 2,870.2 сая төгрөгийн 2 хувь буюу 57,4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 3,441.4 сая төгрөгөөр тогтоосон нь 2019 оны гүйцэтгэлийн зардал өссөнтэй холбоотой болно.

2.7. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 6 төсвийн байгууллага, 2 тусгайн сангийн, нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн нь бүгд аудитад хамрагдсан.



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудаас 3 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт, 2 байгууллагын санхүүгийн тайланд “хязгаарлалттай” дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгаж, илэрсэн асуудлыг нэгтгэсэн тайланд тусгалаа.

Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 209,571.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 209,571.7 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлээ.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгэсэн үзүүлэлт байхгүй байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн залруулга

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд нийт 231.3 сая төгрөгийн залруулга хийлээ. Үүнд:

- *Матад сумын Засаг даргын тамгын газар:* Бусад байгууллагад шилжүүлсэн 194.5 сая төгрөгийн хөрөнгүүдийг данснаас хасах, 11.5 сая төгрөгийн өглөгийн хаах бичилтүүдийг алдаатай хийж, 3.0 сая төгрөгийн бараа материалыг ангиллыг зөрүүлэн бүртгэснийг санхүүгийн тайланд тус тус залруулав.
- *Матад сумын соёлын төв:* Санхүүгийн тодруулга тайланг, дэлгэрэнгүй бүртгэлтэй тулгахад 12.7 сая төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгөд бүртгэснийг аудитын явцад залруулсан байна.
- *Матад сумын Эрүүл мэндийн төв:* Төсөл хөтөлбөрөөс үнэ төлбөргүй олгосон 9,7 сая төгрөгийн эмийг орлогод аваагүй байсныг санхүүгийн тайланд залруулсан байна.

2.8 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

2.8.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 387,679.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 528,335.8 мянган төгрөг болж, 140,656.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	387,679.4	528,326.4	140,647.0	99.9
Банканд байгаа бэлэн мөнгө		9.4	9.4	0.1
Дүн	387,679.4	528,335.8	140,656.4	100.0

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 528,335.8 мянган төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 9.4 мянган төгрөг арилжааны банкны дансанд байршиж байна.

2.8.2 Авлага

Авлагын эхний үлдэгдэл 233,600.6 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 281,686.8 мянган төгрөг болж, 48,086.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөг/



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Зээлийн хүүгийн авлага	221,950.80	275,903.60	53,952.80
Бусад авлага	11,649.80	0.0	-11,649.80
Дүн	233,600.60	275,903.60	42,303.00

Авлагын үлдэгдэлд олон жилийн насжилттай 173,036.8 мянган төгрөгийн дараах авлага байна. Үүнд:

- Сум хөгжүүлэх сангаас олгосон 3-5 жилийн насжилттай 173,036.8 мянган төгрөгийн зээлийн авлага байгааг шүүхэд шилжүүлсэн байна.

Эдгээр нь хөрөнгийн эргэц удааших, сангаас аж ахуй нэгж, иргэнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд үзүүлэх зээл олголтын эх үүсвэр дутагдах зэрэг сөрөг үр дагавартай байна.

2.8.3 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 199,451.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 324,584.8 мянган төгрөг болж, 125,132.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Тусгай зориулалтын материал	17,476.30	18,650.50	1,174.20
Эм боох материал		9,728.60	9,728.90
Дуусаагүй үйлдвэрлэл	3,000.00	0.0	-3,000.00
Бичиг хэргийн материал	1,476.20	202.9	-1,273.30
Аж ахуйн материал	57,307.70	57,874.20	566.5
Сэлбэг хэрэгсэл	20.8		-20.8
Түлш, шатах тослох материал	1,163.90	7,230.70	6,066.80
Барилгын засвар материал	1,000.00	1,000.00	0.0
Хүнсний материал	157.9	2,492.20	0.0
Бусад хангамжийн материал	106,336.90	215,893.40	109,556.50
Мал амьтад	11,512.00	11,512.00	0.0
Дүн	199,451.90	324,584.80	125,133.10

Бараа материалын үлдэгдэлд тайлант оны эцэст нэмэгдсэн нь цэцэрлэг хөрөнгө оруулалтаар 66.2 сая, Засаг даргын тамгын газар нь 35.4 сая төгрөгийн багаж хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан нь голлох нөлөө үзүүлсэн байна.

2.8.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,811,630.0 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,468,359.4 тэрбум төгрөг болж, 656,729.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,621,753.80	2,044,760.40	423,006.60
Тээврийн хэрэгсэл	319,482.50	378,562.50	59,080.00
Машин тоног төхөөрөмж	474,208.00	349,676.50	-124,531.50
Тавилга эд хогшил	131,084.80	130,013.70	-1,071.10
Зам гүүрийн байгууламж	156	156	0.0
Түүх соёлын дурсгалт зүйл	290,000.00	290,000.00	0.0
Дуусаагүй барилга	300,000.00	300,000.00	0.0
Бусад үндсэн хөрөнгө	1,582,216.00	1,883,759.40	301,543.40



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Програм хангамж	4,265.30	2,967.20	-1,298.10
Бусад биет бус хөрөнгө	88,463.40	88,463.40	0.0
Дүн	4,811,630.00	5,468,359.40	656,729.4

Тайлант онд нийт үндсэн хөрөнгө 656.729,4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь төсвөөс 102,427.7 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 728,756.4 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэнтэй холбоотой байна. Тайлант онд сумын ИХТ-ын тогтоолоор акталсан 117,233.3 мянган төгрөг, шилжүүлсэн 159,649.1 мянган төгрөгийн дүнгээр буурсан байна.

2.8.4 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл дэх 22,990.5 мянган төгрөгийг тайлант онд бүрэн төлж үлдэгдэлгүй болсон байна.

Хүснэгт №5. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Байгууллагат өгөх өглөг	22,990.5	0	-22,990.5	
Нийт дүн	22,990.5		-22,990.5	

2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,395,975.8 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 5,216,213.2 мянган төгрөг нэмэгдсэн нь хөрөнгө оруулалттай холбоотой байна.

Хүснэгт № 6. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+/ бууралт /-/	Дүнд эзлэх хувь
<u>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</u>	2,376,418.3	2,376,418.3	0.0	0.0
<u>Хуримтлагдсан үр дүн</u>	1,279,134.8	2,099,372.2	994,578.8	100
<u>Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү</u>	740,422.7	740,422.7	0.0	0.0
Дүн	4,395,975.8	5,216,213.2	994.578.8	100.0

Засгийн газрын оруулсан капитал, хөрөнгийн дахин үнэлгээ дансдад өөрчлөлт гараагүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Матад сумын ИТХ-ын 2019 оны орон нутгийн төсөв батлах тухай 16 дугаар тогтоолд сумын орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого 68,150.0 сая төгрөгөөр батлагдсан нь гүйцэтгэлээр 187,974.9 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 275.8 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 7. Төвлөрүүлэх орлого

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	1,000.0	252.0	748.0	25.2
Шууд бус орлого	25,000.0	135,310.4	-110,310.4	541.2

ДОА-2020/11/СТА-ТТЗ

Formatted: Font: (Default) Arial, Bold, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Bold, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Bold, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Bold, Font color: Auto, Mongolian (Cyrillic)

Formatted: Font: (Default) Arial, Bold, Mongolian (Cyrillic)



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Бууны албан татвар	1,650.0	1,530.0	120.0	92.7
Улсын тэмдэгийн хураамж	2,000.0	2,296.3	-296.3	114.8
Ус, рашаан нөөц ашигласны төлбөр	2,000.0	4,575.4	-2,575.4	228.7
Хүүгийн орлого	11,000.0	15,850.7	-4,850.7	144.1
Торгуулийн орлого	15,500.0	11,437.2	4,062.7	73.7
Бусад орлого	10,000.0	16,722.6	-6,722.6	167.2
Нийт дүн	68,150.0	187,974.9	119,824.9	275.8

Тайлант онд төлөвлөсөн орлого 119,824.9 мянган төгрөгөөр давсан нь шууд бус орлого, ус, рашаан нөөц ашигласны төлбөр, хүүгийн орлого, бусад орлогууд давж биелсэнтэй холбоотой байна. Дээрх орлогууд сүүлийн жилүүдэд байнга давж биелсэн байхад тайлант онд төлөвлөлтийг өөрчлөөгүй байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрт зориулан 2,597,597.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,778,772.3 мянган төгрөгийг урсгал зардалд, 692,825.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,093,285.6 мянган төгрөгийн санхүүжилтийн 909,526.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 26,513.1 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, 64,025.5 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, 371,250.0 мянган төгрөгийг тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,093,285.6 мянга, орон нутгийн төсвөөс 909,526.6 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 22,205.6 мянга, үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос 48,911.0 мянга, тусламжийн эх үүсвэрээс 191,250.0 мянган төгрөг, нийт 2,265,517.8 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлсэн байна.

Төлөвлөсөн дүнгээс 198,421.9 мянган төгрөгийг санхүүжилт дутуу төвлөрсөн нь сум хөгжлийн сангийн үйл ажиллагааны орлого 15,114.5 сая төгрөг, Эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 4,307.4 мянган төгрөг, ОНХС-гийн 180,000.0 мянган төгрөг, СХС-гийн зээлийн эргэн төлөлтийн орлого 15,114.4 мянган төгрөг нийт 199,421.8 мянган төгрөгийн орлого дутуу санхүүжүүлснээс шалтгаалан тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,265,517.8 мянган төгрөг буюу 87,2 хувьтай байгаагаас, 8 хувь нь санхүүжилт дутуу төвлөрсөн, 4.8 хувь нь орон тоо дутуу ажилласан, хэмнэлтээс үүссэн зэргээс шалтгаалсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 692,825.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 482,825.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, БХС-гийн барьцаа дансанд 3,100.0 мянган төгрөг, Төрийн сангийн дансанд 66,164.1 мянган төгрөг захиалагчийн хяналтын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсөв: Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,437.5 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 52,955.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 13,348.4 мянган төгрөг, нийт 68,741.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 3,637.3 мянган төгрөг, нормативт зардал 1,947.7 мянган төгрөг, Эд хогшил, урсгал засварын зардалд 4,810.0 мянган төгрөг, Бараа үйлчилгээний бусад зардалд 1,619.8 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 280.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 36,325.2 мянган төгрөг нийт 68,741.1 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэлгүй байна.

2.10. ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Сумын Засаг дарга нь захирамж гарган Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ыг зөрчин, урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд хөрөнгө зарцуулсан байна.

2. Матад сум нь 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 16 тогтоолоор сумын 2019 оны төсвийг баталсан байна. Тус төсөвт 1 удаа "төсөвт нэршил өөрчлөх" гэсэн нэрээр төсвийн тодотгол хийсэн нь Төсвийн тухай хуульд нийцэхгүй байна.



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

3. Матад сумын ЕБС нь санхүүгийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт авсан. Төрийн аудитын тухай хуулийн 28.1 дэх заалтын дагуу төсвийн шууд захирагчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлэх.

Дээрх асуудлуудыг төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайланд тусгах саналтай байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Матад сум нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 145 мэдээллийг хугацаанд нь, 56 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн 74.348.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж, 1 албан шаардлага хүргүүлснээс 3 зөвлөмж, 1 албан шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

Албан шаардлага, зөвлөмж хүргүүлсэн 2019 оны 06 сарын 23 өдрийн албан бичгээр Төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Матад сумын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн мөнгөн гүйлгээ, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНБООУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төлөвлөлттэй холбоотой холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Тайлант оны орлогын төлөвлөгөө 175.9 хувиар буюу 119.8 сая төгрөгөөр давж биелсэн нь орлогыг бодитой төлөвлөөгүйтэй холбоотой байна.

3.1.2 Эрсдэл: Хөтөлбөрүүд бүрэн төлөвлөгдөж, хэрэгжихгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Төсвийг тооцоо судалгаанд үндэслэн бодитой төлөвлөх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны 11 дүгээр сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эцсийн үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	820 731 979,16	1 128 824 173,94
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	387 679 403,54	528 335 820,16
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	-	9 400,00
31140	Касс арилжааны банк		9 400,00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	387 679 403,54	528 326 420,16
3121	Төгрөг	387 679 403,54	528 326 420,16
31211	Төрийн сангийн харилцах	387 679 403,54	528 326 420,16
33	АВЛАГА	233 600 643,00	275 903 547,00
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	156 000,00	
335	Бусад авлага	233 444 643,00	275 903 547,00
3351	Байгууллагаас авах авлага	11 493 800,00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	221 950 843,00	275 903 547,00
35	БАРАА МАТЕРИАЛ	199 451 932,62	324 584 806,78
351	Түүхий эд материал	17 476 354,35	28 379 156,66
35110	Тусгай зориулалттай материал	17 476 354,35	18 650 554,35
35130	Эм боох материал		9 728 602,31
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	3 000 000,00	
354	Хангамжийн материал	167 463 578,27	284 693 650,12
35410	Бичиг хэргийн материал	1 476 203,00	202 953,00
35420	Аж ахуйн материал	57 307 743,70	57 874 243,70
35430	Сэлбэг хэрэгсэл	20 800,00	
35440	Түлш, шатах тослох материал	1 163 970,25	7 230 712,00
35450	Барилгын засварын материал	1 000 000,00	1 000 000,00
35460	Хүнсний материал	157 904,60	2 492 294,70
35470	Бусад хангамжийн материал	106 336 956,72	215 893 446,72
35600	Мал амьтад	11 512 000,00	11 512 000,00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3 598 234 482,79	4 081 605 801,78
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3 598 234 482,79	4 081 605 801,78
392	Биет хөрөнгө	3 508 363 582,83	3 992 598 559,92
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 621 753 852,26	2 044 760 452,26
39202	Хуримтлагдсан элэгдэл	(51 121 911,48)	(102 760 706,25)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	319 482 556,40	378 562 556,40
39204	Хуримтлагдсан элэгдэл	(204 112 879,00)	(251 405 971,66)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	474 208 007,47	349 676 596,97
39206	Хуримтлагдсан элэгдэл	(265 852 590,53)	(235 977 301,31)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	131 084 899,57	130 013 744,60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(78 783 334,94)	(58 407 779,18)
39209	Зам, гүүрийн байгууламж	156 000,00	156 000,00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(76 816,63)	(129 899,78)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	290 000 000,00	290 000 000,00
39214	Бусад үндсэн хөрөнгө	1 582 216 029,29	1 883 759 488,29
39215	Хуримтлагдсан элэгдэл	(610 590 229,58)	(735 648 620,42)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	300 000 000,00	300 000 000,00

ДОА-2020/11/СТА-ТТ3



Матад сумын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	89 870 899,96	89 007 241,86
39301	Програм хангамж	4 265 300,00	2 967 200,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2 857 800,04)	(1 779 470,10)
39303	Бусад биет бус хөрөнгө	88 463 400,00	88 463 400,00
39304	Хуримтлагдсан элэгдэл		(643 888,04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4 418 966 461,95</u>	<u>5 210 429 975,72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>22 990 502,00</u>	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	22 990 502,00	-
413	Өглөг	22 990 502,00	-
4136	Бусад өглөг	22 990 502,00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	22 990 502,00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4 395 975 959,95</u>	<u>5 210 429 975,72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4 395 975 959,95	5 210 429 975,72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 376 418 308,63	2 376 418 308,63
512	Хуримтлагдсан үр дүн	1 279 134 868,88	2 093 588 884,65
51210	Өмнөх үеийн үр дүн	1 651 995 600,52	1 279 134 868,88
51220	Тайлант үеийн үр дүн	(372 860 731,64)	814 454 015,77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	740 422 782,44	740 422 782,44
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4 418 966 461,95</u>	<u>5 210 429 975,72</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /мянган төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2 364 937 956,78	3 990 374 301,93
11	ТАТВАРЫН ОРЛОГО	66 858 952,42	143 964 303,04
110	Орлогын албан татвар	58 241 042,42	135 562 498,04
1100	Хувь хүний орлогын албан татвар	58 241 042,42	135 562 498,04
110002	Үйл ажиллагааны орлого	895 000,00	252 000,00
110008	Шууд бус орлого	57 346 042,42	135 310 498,04
113	Хөрөнгийн албан татвар	1 940 000,00	1 530 000,00
113002	Бууны албан татвар	1 940 000,00	1 530 000,00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	6 677 910,00	6 871 805,00
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2 120 382,00	2 296 320,00
118001	Улсын тэмдэгтийн хураамж	2 120 382,00	2 296 320,00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4 557 528,00	4 575 485,00
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	4 557 528,00	4 575 485,00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	287 587 944,93	1 183 579 097,34
120	Нийтлэг татварын бус орлого	287 587 944,93	992 329 097,34
120002	Хүүгийн орлого	11 074 241,71	15 850 793,43
120003	Торгуулийн орлого	32 034 150,00	11 437 272,80
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	171 269 153,22	948 318 422,31
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	930 000,00	2 891 674,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1 100 000,00	3 100 000,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	169 239 153,22	942 326 748,31
120005	Түрээсийн орлого	292 200,00	
